



Өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоо ТА ТООЦООЛ, ХЭРЭГЖҮҮЛ, ХЭМНЭ


Та гэрийнхээ хөргөгч, телевизор, цахилгаан зуух г.м цахилгаан хэрэгсэлүүдийн цахилгааны төлбөрт сард, жилд хэдэн төгрөг төлдөгөө тооцоолж үзсэн үү? Хэрэв тооцоолж үзээгүй бол тооцоолоод үзээрэй, таны мөнгийг хэмнэх боломж гарах ч юм билүү!

Та тооцоолол хийхийн тулд цахилгаан хэрэгсэлийнхээ нэгжийн хүчин чадал, хоногт болон 7 хоногт хэдэн цаг ажиллуулдаг цагаа мэдэж байх шаардлагатай.


Ахуйн цахилгаан хэрэгсэлийн нэгжийн хүчин чадлыг хаанаас харах вэ?

а/ Цахилгаан хэрэгсэлийг дагалдаж ирдэг заавар номноос;

б/ Цахилгаан хэрэгсэл дээр наасан техникийн үзүүлэлтээс;



Technical Specifications			
Model name	NN-SM323MW	NN-ST342MW	
Power Source	230 V, 50 Hz	230 - 240 V, 50 Hz	230 - 240 V, 50 Hz
Power Consumption	5.9 A, 1,270 W	5.5 A, 1,270 W	5.9 A, 1,270 W
Cooking Power*		800 W	
Outside Dimensions	485 mm (H) x 287 mm (W) x 400 mm (D)		
Oven Cavity Dimensions	315 mm (H) x 277 mm (W) x 349 mm (D)		
Oven Cavity Volume	25 L		
Oven Tray Diameter	238 mm		
Operating Frequency	2,450 MHz		
Net Weight	Approx. 12.4 kg		Approx. 12.7 kg



Нэгжийн хүчин чадал

Нэгжийн хүчин чадал

Харин плитка, телевизор, чийдэн г.м цахилгаан хэрэгсэлээ хоногт болон 7 хоногт хэдэн цаг ажиллуулдагаа та өөрөө мэдэж байгаа. Ажиллах цаг нь айл өрхийн хэрэглээнээс хамаараад харилцан адилгүй байна.

Зарим цахилгаан барааны сар, жилийн цахилгааны төлбөрийг тооцоолж үзвэл:

Плитка: нэгжийн хүчин чадал 2300 Вт

Хоногт ажиллах цаг 1 цаг

$2300 \text{ Вт} \cdot 1 \text{ цаг} = 2300 \text{ Вт.ц}$ буюу 2.3 кВт.ц /хоногийн хэрэглээ/

$2.3 \text{ кВт.ц} \cdot 30 \text{ хоног} = 69 \text{ кВт.ц}$ /сарын хэрэглээ/

$69 \text{ кВт.ц} \cdot 130 \text{ төг/кВт.ц} = 8,970 \text{ төг}$ /сарын төлбөр/

$69 \text{ кВт.ц} \cdot 12 \text{ сар} = 828 \text{ кВт.ц}$ /жилийн хэрэглээ/

$828 \text{ кВт.ц} \cdot 130 \text{ төг/кВт.ц} = 107,640 \text{ төг}$ /жилийн төлбөр/

Бусад цахилгаан хэрэгсэлийн хэрэглээний тооцоог хүснэгт 1-т харууллаа.


Өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоо

№	Цахилгаан хэрэгсэл	тоо ширхэг	Нэгжийн хүчин чадал /Вт/	Хоногт ажиллах /цаг/	7 хоногт ажиллах /цаг/	Сарын хэрэглээ /кВт.ц/	Сарын хэрэглээнд эзлэх хувь	Жилийн хэрэглээ /кВт.ц/	Сарын төлбөр /төгрөг/	Жилийн төлбөр /төгрөг/
1	Хөргөгч	1	200	7.0	49.0	42.0	13%	504.0	5,460.0	65,520.0
2	Ширмэн плитка	1	2,300	1.0	7.0	69.0	21%	828.0	8,970.0	107,640.0
3	Богино долгионы зуух	1	1,200	0.3	2.1	10.8	3%	129.6	1,404.0	16,848.0
4	Будаа агшаагч	1	820	-	2.0	8.0	2%	96.0	1,040.0	12,480.0
5	ТВ	1	130	8.0	56.0	31.2	10%	374.4	4,056.0	48,672.0
6	Угаалгын машин	1	1,700	-	6.0	24.0	7%	288.0	3,120.0	37,440.0
7	Тоос сорогч	1	1,800	0.3	2.1	16.2	5%	194.4	2,106.0	25,272.0
8	Индүү	1	2,600	-	1.5	6.0	2%	72.0	780.0	9,360.0
9	Ус буцалгагч /халуунаа барьдаг/	1	1,500	1.0	7.0	45.0	14%	540.0	5,850.0	70,200.0
10	Үсний сэнс	1	800	0.2	1.4	4.8	1%	57.6	624.0	7,488.0
11	Ухаалаг утас цэнэглэгч	2	10	1.0	7.0	0.3	0%	3.6	39.0	468.0
12	Улайсдаг чийдэн /60 Вт/	6	360	6.0	42.0	64.8	20%	777.6	8,424.0	101,088.0
	ДҮН	18	13,420	24.8	183.1	322.1	100%	3,865.2	41,873.0	502,476.0

Тайлбар: Айл өрхийн цахилгааны тарифыг /НӨАТ-тай/ энгийн тоолууртай бол:

Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц хүртэл хэрэглээг 108.24 төг/кВт.ц

Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц болон түүнээс дээш хэрэглээг 130 төг/кВт.ц-аар тооцдог бөгөөд дээрх тооцоог 130 төг/кВт.ц-аар тооцсон болно.



Хүснэгт 1-ээс харахад плитка, чийдэн нь өрхийн сарын цахилгааны хэрэглээнд өндөр хувийг эзэлж байна. Тэгвэл эдгээр хэрэгсэлийг эрчим хүчний хэмнэлттэй хэрэгсэлээр солиход хэдэн төгрөгийн хэмнэлт гарахыг хүснэгт 2-оос харьцуулан харъя.

Өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоо

Эрчим хүчний хэмнэлттэй хэрэгсэлээр солих тооцоо

№	Цахилгаан хэрэгсэл	тоо ширхэг	Нэгжийн хүчин чадал /Вт/	Хоногт ажиллах /цаг/	Сарын хэрэглээ /кВт.ц/	Сарын төлбөр /төгрөг/	Эрчим хүчний хэмнэлттэй хэрэгсэл	Нэгжийн хүчин чадал /Вт/	Хоногт ажиллах /цаг/	Сарын хэрэглээ /кВт.ц/	Сарын төлбөр /төгрөг/
1	Хөргөгч	1	200	7.0	42.0	5,460.0	Хөргөгч	200	6.0	36.0	4,680.0
2	ширмэн плитка	1	2,300	2.0	138.0	17,940.0	Индукцийн плитка	2,300	1.0	69.0	8,970.0
3	LCD ТВ	1	130	8.0	31.2	4,056.0	Лед ТВ	75	8.0	18.0	2,340.0
4	ус буцалгагч /халуунаа барьдаг/	1	1,500	1.0	45.0	5,850.0	Түргэн буцалгагч	1,500	0.5	22.5	2,925.0
5	Улайсдаг чийдэн /60 Вт/	6	360	6.0	64.8	8,424.0	Лед чийдэн /5 Вт/	30	6.0	5.4	702.0
	ДҮН	10	4,490	24.0	321.0	41,730.0	ДҮН	4,105	21.5	150.9	19,617.0



Хуучин болон шинэ загварын хөргөгч, плитка гэх зэрэг зарим цахилгаан хэрэгсэлүүдийн нэгжийн хүчин чадал адилхан ч эрчим хүчний хэмнэлтийн А /А+, А++/ тэмдэглэгээтэй хэрэгсэлүүд нь цахилгаан бага зарцуулдаг. Хүснэгт 2-т хөргөгч, плитка, ус буцалгагчийн ажиллах цагийг богиносгож, телевиз, чийдэнг нэгжийн хүчин чадал багатай хэмнэлттэйгээр сольж тооцоолоход сард 22,113 төгрөгийн хэмнэлт гарч байна.

Мэдээж сүүлийн үеийн эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэлүүдийг худалдаж авахад хуучин загвараа бодвол арай илүү үнэтэй байгаа. Тэгвэл худалдан авсан өртгөө хэдий хугацаанд нөхөж ашиг олохыг тооцоолъё.

Плитка: Судалгаанаас харахад индукцийн плитка нь газан плитканаас 3 минут, керамикаас 3.2 минут, ширмэн плитканаас 3.8 минут хурдан халдаг, ширмэн плиткатай харьцуулахад цахилгааныг 90% хүртэл хэмнэдэг байна.


Индукцийн плитка зах зээлийн дундаж үнэ 115,000₮

Хүснэгт 2-оос: $17,940 - 8970 = 8,970$ төг /сарын хэмнэлт/

$8,970 * 12$ сар = 107,640 төг /жилийн хэмнэлт/

Өртгөө нөхөх хугацаа: $115,000 : 107,640 = 1,1$ жил

Чийдэн: Судалгаанаас харахад цахилгаан бага хэрэглэдэг, гэрэлтүүлэг сайтай эрчим хүчний хэмнэлттэй гэрлийн шил ашигласнаар та ердийн улайсдаг чийдэнгээс 10 дахин урт хугацаанд ашиглаж, 60 хувь бага эрчим хүч зарцуулна.



5 Вт-ын Лед чийдэнгийн зах зээлийн дундаж үнэ 8000₮ * 6ш = 48,000₮

Хүснэгт 2-оос: $8,424 - 3,088.8 = 5,335.2$ төг /сарын хэмнэлт/

$5,335.2 * 12$ сар = 64,022.4 төг /жилийн хэмнэлт/

Өртгөө нөхөх хугацаа: $48,000 : 64,022.1 = 0.75$ жил

Эхний ээлжинд үнэ харьцангуй багатай плитка, чийдэнгээ сольсноор та сард **14,305** төгрөг, жилд **171,662** төгрөгийн хэмнэлт гаргаж, 1 жил хагасын дараагаас цэвэр ашгаа хүртэх боломжтой байна.

Цахилгаан хэрэгсэлүүд нь загвар, хэмжээ, техникийн үзүүлэлт зэргээсээ хамаараад зах зээл дээрх үнэ нь харилцан адилгүй нь ойлгомжтой. Иймд та цахилгаан хэрэгсэл авахаар бол эхлээд тооцооллоо сайн хийхийг зөвлөж байна.

Хэрэв цахилгаан хэрэгсэлээ эрчим хүчний хэмнэлттэй хэрэгсэлээр солих боломжгүй гэж бодож байгаа бол доорх энгийн зөвлөгөөг хэрэгжүүлж цахилгааны сарын төлбөрөө багасгаж, мөнгөө хэмнэх боломж ч байна.



Ашиглаагүй гэрлээ унтрааж хэвших.

Зөвхөн өөрт шаардлагатай хэмжээний усыг л буцалгах.

Угаалгын машин, аяга таваг угаагч зэргийг бүрэн дүүргэсний дараа ажиллуулж байх.

Цахилгаан хэрэгсэлүүд /телевизор, олон салаа залгуур г.м/-ийг улаан гэрэлтэй орхихгүй байх. Бүрэн унтраагаагүй улаан гэрэлтэй үед эдгээр нь цахилгааныг хэрэглэж л байдаг.



Утсаа залгахгүйгээр цэнэглэгчийг нь залгаатай орхиход хүртэл цахилгаан гүйдэг. Бүрэн унтраагаагүй, салгаагүй эдгээр цахилгааны алдагдлыг **standby or vampire power losses** /цус сорогч/ гэж нэрлэдэг байна.

Хоол бэлтгэх саваа таарсан тагтай, тэгш хавтгай ёроолтой, ёроолын гадаргуугийн хэмжээ нь плитканы ширэмний хэмжээтэй адил байлгах.

Хөргөгчийг плитка, ус буцалгагч зэрэг дулаан ялгаруулдаг хэрэгсэлээс хол байрлуулах.

Индүүдэх бүх зүйлээ нэг дор, хувцасны төрөлдөө тохируулж температурыг бууруулах дарааллаар индүүдэх.